



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 113

МАНДАЛГОВЬ

**Үндсэн хөрөнгө бүртгэх,
данс хооронд шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

Нэг: Дундговь аймаг дахь Цагдаагийн газарт хандиваар ирсэн 8,500,000 /найман сая таван зуун мянга/ төгрөгийн үнэтэй Форд транзит маркын автомашиныг үндсэн хөрөнгөнд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Дундговь аймаг дахь Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа О.Амарсанаад даалгасугай.

Гурав: Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 04-р улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

